



ТАВАНТОЛГОЙ ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 01

Цогтүэний сум

“Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны
болон санхүүгийн тайланг танилцуулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.14 дэх заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.9 дэх заалт, Тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн дэлгэрэнгүй тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.
2. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад зохих мэдээллийг хувьцаа эзэмшигчид, олон нийтэд журмын дагуу хүргэж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ОТГОНБАЯР



ТАВАНТОЛГОЙ ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 02

Цогтцэний сум

“Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг хэлэлцсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
дүгнэлт батлах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.9 дэх заалт, Тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 20, 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг баталсугай.
2. Хуралд танилцуулсан дүгнэлтийг цаашид бодлого шийдвэртээ тусгаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ОТГОНБАЯР



ТАВАНТОЛГОЙ ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 03

Цогтцэний сум

“Тавантолгой” ХК-ийн 2023 оны цэвэр ашгаас ногдол
ашиг хуваарилан олгосон тайланг танилцуулах тухай


Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.15 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.13 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.4.11 дэх заалт, Тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2023 оны жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахтай холбоотойгоор 2024 оны тайлант жилд гүйцэтгэсэн ногдол ашиг тараах үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.
2. Ногдол ашиг хуваарилан олгосон тухай мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хувьцаа эзэмшигчид, олон нийтэд мэдээлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ОТГОНБАЯР





ТАВАНТОЛГОЙ ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 04

Цогтцэний сум

“Тавантолгой” ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас
ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.13 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.4.11 дэх заалт, Тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 11 дүгээр тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийн дагуу ногдол ашиг хуваарилах, хувьцаа эзэмшигчдэд бүрэн олгох ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ОТГОНБАЯР





ТАВАНТОЛГОЙ ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 05

Цогтнэший сум

“Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.13 дахь заалт, Тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.
2. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлант жилийн хугацаанд гүйцэтгэсэн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ОТГОНБАЯР





ТАВАНТОЛГОЙ ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 06

Цогцээний сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон
хараат бус гишүүдийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.2, 77.4 дэх хэсэг, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9, 6.14.7 дахь заалт, Тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн, хараат бус гишүүдийг хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналыг кумулятив аргаар тоолж нэгтгэсэн дүнд үндэслэн дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай. Үүнд:

1. Шаравын Отгонбаяр /ердийн гишүүн/
2. Бямбаагийн Мэндбаяр /ердийн гишүүн/
3. Эрдэнэчулууны Бөхбат /ердийн гишүүн/
4. Сүрэнхүүгийн Мятавдорж /ердийн гишүүн/
5. Цэнд-Аюушийн Цэнгэлбаяр /ердийн гишүүн/
6. Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ /ердийн гишүүн/
7. Чинзоригийн Отгонбаяр /хараат бус гишүүн/
8. Батцэцэгийн Батсүрэн /хараат бус гишүүн/
9. Даваадоржийн Дэлгэрцогт /хараат бус гишүүн/

2. Шинээр сонгогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг холбогдох хууль тогтоомжид заасан эрх, үүргийн хүрээнд идэвхи санаачлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ОТГОНБАЯР





ТАВАНТОЛГОЙ ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 07.

Цогтцэний сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны
төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.12, 6.14.13 дахь заалт, Тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн 2024 оны үйл ажиллагааны үр дүнгийн урамшууллын хэмжээг нэгдүгээр, 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн мөрдөх цалингийн хэмжээг хоёрдугаар, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төсвийг гуравдугаар хавсралтаар баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цалин урамшууллын дэд хороонд, Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөвт тусгагдсан зардлыг санхүүжүүлж ажиллахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ОТГОНБАЯР

